



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2025/063/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 70007734 Цахим хаяг: <a href="mailto:boldch@audit.gov.mn">boldch@audit.gov.mn</a> Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>  Аудитын менежер Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:otgonbayarda@audit.gov.mn">otgonbayarda@audit.gov.mn</a>  Ахлах аудитор: М.Ундармаа Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:undarmaam@audit.gov.mn">undarmaam@audit.gov.mn</a> Аудитор: Л.Одонтуяа Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:Odontuyal@audit.gov.mn">Odontuyal@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Тайлант онд үндсэн үйл ажиллагааны зардлын 77.6 хувийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Төрийн аудитын байгууллагад 2024 оны санхүүгийн тайлан, холбогдох мэдээ, мэдээлэл, баримт материалыг хуулийн хугацаанд бүрэн, үнэн зөв ирүүлээгүйгээс аудит хийхэд хүндрэл, цаг хугацааны хязгаарлагдмал байдал үүсгэсэн, завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Санхүүгийн программд нягтлан бодох бүртгэлийг зөрүүтэй хөтөлж санхүүгийн тайланг эксел хүснэгтээр гаргаж ирүүлсэн. Тухайн тайланд нийгмийн даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийг үндсэн үйл ажиллагааны орлогоор тайлагнаж, үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогыг бүртгээгүй 199,890.7 мянган төгрөгийн алдааг нягтлан бодогч залруулаагүй болно.

#### **Бусад асуудал**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг эрх бүхий байгууллага 96.0 хувиар хэрэгжсэн гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн 2024 оны санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>43,820,305.82</b>	<b>31,217,860.94</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>5,136,084.40</b>	<b>0.00</b>
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	687,905.13	0.00
31110	Төгрөг	687,905.13	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,448,179.27	0.00
31210	Төгрөг	4,448,179.27	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	4,448,179.27	0.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>14,728,472.37</b>	<b>3,000,000.00</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	13,325,030.00	0.00
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	643,442.37	0.00
33500	Бусад авлага	760,000.00	3,000,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	760,000.00	3,000,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>23,955,749.05</b>	<b>28,217,860.94</b>
35400	Хангамжийн материал	23,955,749.05	28,217,860.94
35410	Бичиг хэргийн материал	610,750.00	1,817,470.81
35420	Аж ахуйн материал	5,701,122.46	7,874,208.17
35430	Сэлбэг хэрэгсэл	14,212,029.60	10,878,761.10
35440	Түлш, шатах тослох материал	3,431,846.99	7,647,420.86
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,387,168,000.86</b>	<b>2,850,360,933.60</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,387,168,000.86</b>	<b>2,850,360,933.60</b>
39200	Биет хөрөнгө	3,296,800,081.19	2,759,993,013.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,046,168,087.00	2,046,168,087.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-274,979,464.74	-324,394,489.93
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,959,674,689.30	4,602,095,405.35
39204	Хуримтлагдсан элэгдэл	-4,559,253,220.21	-3,660,138,940.04
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	153,143,700.00	156,464,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-93,700,744.50	-109,477,225.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,273,993.00	86,907,793.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-37,119,362.73	-57,990,565.46
39214	Бусад үндсэн хөрөнгө	120,041,940.00	134,791,940.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-86,449,535.93	-114,433,590.28
39300	Биет бус хөрөнгө	90,367,919.67	90,367,919.67
39303	Бусад биет бус хөрөнгө	104,267,920.00	104,267,920.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-13,900,000.33	-13,900,000.33
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,430,988,306.68</b>	<b>2,881,578,794.54</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,193,696,018.27</b>	<b>814,844,772.80</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,193,696,018.27</b>	<b>814,844,772.80</b>
41300	Өглөг	74,913,119.12	255,592,163.07
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	346,171.90
41360	Бусад өглөг	74,913,119.12	255,245,991.17
41361	Байгууллагад төлөх өглөг	27,208,771.00	0.00
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	47,704,348.12	157,957,224.85
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	0.00	97,288,766.32
41400	Урьдчилж орсон орлого	1,118,782,899.15	559,252,609.73
41440	Бусад урьдчилж орсон орлого	1,118,782,899.15	559,252,609.73
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,237,292,288.41</b>	<b>2,066,734,021.74</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,237,292,288.41	2,066,734,021.74

**Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	2,841,983,847.16	2,841,983,847.16
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	85,537,920.00	85,537,920.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-1,836,359,014.02	-2,006,917,280.69
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,693,451,424.96	-1,836,359,014.02
51220	Тайлант үеийн үр дүн	-142,907,589.06	-170,558,266.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,146,129,535.27	1,146,129,535.27
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,430,988,306.68</b>	<b>2,881,578,794.54</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,295,808,560.65</b>	<b>4,162,142,070.51</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,295,808,560.65</b>	<b>4,162,142,070.51</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,295,808,560.65</b>	<b>4,162,142,070.51</b>
120002	Хүүгийн орлого	0.00	43,644.19
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,183,063,360.65</b>	<b>1,437,754,966.32</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	929,698,157.29	1,427,209,017.32
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	253,365,203.36	10,545,949.00
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	2,112,745,200.00	2,724,343,460.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,438,716,149.71</b>	<b>4,332,700,337.18</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,438,716,149.71</b>	<b>4,332,700,337.18</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,438,716,149.71</b>	<b>4,332,700,337.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,693,399,592.43</b>	<b>2,430,931,134.65</b>
210101	Үндсэн цалин	1,693,399,592.43	2,430,931,134.65
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>383,171,554.00</b>	<b>531,866,109.57</b>
210201	Тэтгэврийн даатгал	383,171,554.00	531,866,109.57
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>36,064,681.13</b>	<b>119,907,685.43</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,817,634.93	12,232,146.66
210302	Түлш, халаалт	12,232,059.07	14,051,100.64
210303	Цэвэр, бохир ус	8,014,987.13	6,143,838.13
210304	Байрны түрээс	0.00	87,480,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>642,585,082.15</b>	<b>631,505,576.39</b>
210401	Бичиг хэрэг	6,620,329.74	15,062,080.00
210402	Тээвэр, шатахуун	555,553,409.76	557,174,552.77
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21,393,330.76	21,940,480.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,560,000.00	1,560,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	57,458,011.89	35,768,463.62
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>58,276,210.34</b>	<b>55,553,559.52</b>
210604	Урсгал засвар	58,276,210.34	55,553,559.52
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,240,000.00</b>	<b>10,590,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,240,000.00	10,590,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>184,255,542.89</b>	<b>145,254,353.13</b>
210803	Даатгалын үйлчилгээ	8,098,650.00	12,671,502.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	8,167,594.00	16,060,600.00

**Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210807	Газрын төлбөр	770,329.00	741,305.50
210813	Бусад зардал /ТӨҮГ/	167,218,969.89	115,780,845.63
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>433,723,486.77</b>	<b>407,092,018.49</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	433,723,486.77	407,092,018.49
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-142,907,589.06</b>	<b>-170,558,266.67</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-142,907,589.06</b>	<b>170,558,266.67</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,325,841,442.57</b>	<b>4,162,142,070.51</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,325,841,442.57</b>	<b>4,162,142,070.51</b>
120	Нийтлэг татварын бус орлого	3,325,841,442.57	4,162,142,070.51
120002	Хүүгийн орлого	0.00	43,644.19
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,213,096,242.57	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,202,099,545.25	1,427,209,017.32
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,996,697.32	10,545,949.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	2,112,745,200.00	2,724,343,460.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,325,553,548.00</b>	<b>4,171,663,147.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,325,553,548.00</b>	<b>4,171,663,147.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,325,553,548.00</b>	<b>4,171,663,147.91</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,748,864,046.04	2,492,782,629.66
210101	Үндсэн цалин	1,748,864,046.04	2,492,782,629.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	402,171,554.00	531,866,109.57
210201	Тэтгэврийн даатгал	402,171,554.00	531,866,109.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,458,011.89	119,907,685.43
210301	Гэрэл, цахилгаан	38,458,011.89	12,232,146.66
210302	Түлш, халаалт	0.00	14,051,100.64
210303	Цэвэр, бохир ус	0.00	6,143,838.13
210304	Байрны түрээс	0.00	87,480,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	946,277,911.10	798,519,753.41
210401	Бичиг хэрэг	0.00	15,062,080.00
210402	Тээвэр, шатахуун	807,058,054.62	615,952,817.89
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.00	21,940,480.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	1,560,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	139,219,856.48	144,004,375.52
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	15,098,334.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	8,098,334.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	7,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	0.00	10,020,000.00
210702	Дотоод албан томилолт	0.00	10,020,000.00

**Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	189,782,024.97	203,468,635.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	314,007.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	118,760,316.88	97,583,210.73
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	8,098,650.00	16,060,600.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	62,923,058.09	89,510,818.11
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>287,894.57</b>	<b>-742,384.40</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>6,262,000.00</b>	<b>4,393,700.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,262,000.00</b>	<b>4,393,700.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	6,262,000.00	4,393,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,262,000.00	4,393,700.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-6,262,000.00</b>	<b>-4,393,700.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-5,974,105.43</b>	<b>-5,136,084.40</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,110,189.83	5,136,084.40
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,136,084.40	0.00

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,927,521,767.16	1,146,129,535.27	-1,693,451,424.96	2,380,199,877.47
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,927,521,767.16	1,146,129,535.27	-1,693,451,424.96	2,380,199,877.47
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-142,907,589.06	-142,907,589.06
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,927,521,767.16	1,146,129,535.27	-1,836,359,014.02	2,237,292,288.41
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,927,521,767.16	1,146,129,535.27	-1,836,359,014.02	2,237,292,288.41
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,927,521,767.16	1,146,129,535.27	-1,836,359,014.02	2,237,292,288.41
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-170,558,266.67	-170,558,266.67
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,927,521,767.16	1,146,129,535.27	-2,006,917,280.69	2,066,734,021.74

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,555,586,100.00</b>	<b>3,511,302,514.32</b>	<b>44,283,585.68</b>	<b>98.8</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,555,586,100.00</b>	<b>3,511,302,514.32</b>	<b>44,283,585.68</b>	<b>98.8</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,497,021,000.00</b>	<b>3,454,911,854.32</b>	<b>42,109,145.68</b>	<b>98.8</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,537,535,800.00	2,512,277,338.59	25,258,461.41	99.0
210101	Үндсэн цалин	1,268,110,300.00	1,182,053,317.79	86,056,982.21	93.2
210102	Нэмэгдэл	726,575,500.00	822,427,661.25	-95,852,161.25	113.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	542,850,000.00	488,301,650.62	54,548,349.38	90.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	317,192,000.00	317,192,000.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	215,690,500.00	215,690,500.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	25,375,300.00	25,375,300.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	20,102,300.00	20,102,300.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	5,273,100.00	5,273,100.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	50,750,800.00	50,750,800.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108,650,000.00	102,209,641.73	6,440,358.27	94.1
210301	Гэрэл, цахилгаан	8,400,000.00	5,407,199.44	2,992,800.56	64.4
210302	Түлш, халаалт	6,750,000.00	5,862,271.27	887,728.73	86.8
210303	Цэвэр, бохир ус	3,500,000.00	3,459,571.02	40,428.98	98.8
210304	Байрны түрээс	90,000,000.00	87,480,600.00	2,519,400.00	97.2
2104	Хангамж, бараа материалын зардал	308,049,000.00	307,552,154.00	496,846.00	99.8
210401	Бичиг хэрэг	7,200,000.00	7,200,000.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	274,000,000.00	273,999,294.00	706.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,099,000.00	14,606,072.00	492,928.00	96.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	910,000.00	910,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,840,000.00	10,836,788.00	3,212.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	114,000,000.00	113,840,433.00	159,567.00	99.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,000,000.00	11,068,234.00	-68,234.00	100.6
210602	Тавилга	1,500,000.00	1,274,900.00	225,100.00	85.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,000,000.00	7,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	94,500,000.00	94,497,299.00	2,701.00	100.0
2107	Томилот, зочны зардал	10,500,000.00	10,020,000.00	480,000.00	95.4
210702	Дотоод албан томилот	10,500,000.00	10,020,000.00	480,000.00	95.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,424,500.00	20,161,140.00	9,263,360.00	68.5
210803	Даатгалын үйлчилгээ	11,800,000.00	11,800,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	10,894,200.00	2,003,640.00	8,890,560.00	18.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,000,000.00	627,200.00	372,800.00	62.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	730,300.00	730,300.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	71,669,700.00	71,659,147.00	10,553.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,669,700.00	70,659,147.00	10,553.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,565,100.00	56,390,660.00	2,174,440.00	96.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,565,100.00	56,390,660.00	2,174,440.00	96.3
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,165,100.00	26,506,160.00	1,658,940.00	94.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,400,000.00	29,884,500.00	515,500.00	98.3
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,555,586,100.00</b>	<b>3,511,302,514.32</b>	<b>44,283,585.68</b>	<b>98.8</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,726,517,900.00</b>	<b>2,723,558,203.00</b>	<b>2,959,697.00</b>	<b>99.9</b>
320001	Орон нутгийн төсвөөс	<b>2,726,517,900.00</b>	<b>2,723,558,203.00</b>	<b>2,959,697.00</b>	<b>99.9</b>
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>829,068,200.00</b>	<b>787,744,311.32</b>	<b>41,323,888.68</b>	<b>95.0</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	<b>829,068,200.00</b>	<b>787,744,311.32</b>	<b>41,323,888.68</b>	<b>95.0</b>
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>211</b>	<b>211</b>	<b>0</b>	<b>100.0</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>100.0</b>
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>105</b>	<b>105</b>	<b>0</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	103	103	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	1	1	0	100.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>105</b>	<b>105</b>	<b>0</b>	<b>100.0</b>
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	105	105	0	100.0

## Гурав.Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 2,918,659.9 мянган төгрөгийн 4 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

### Залруулсан алдаа:

- Худалдан авсан 2,969.9 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй,
- Үндсэн үйл ажиллагааны 2,743,711.7 мянган төгрөгийн орлогыг дансны ангилал зөрүүлэн тайлагнасан,
- Цалин хөлстэй холбоотой 171,632.0 мянган төгрөгийн өр төлбөрийг дутуу бүртгэсэн,
- Ажилчдаас илүү тооцон суутгасан 346.3 мянган төгрөгийн НДШ-ийг өр төлбөрөөр бүртгээгүй,

Эдгээр нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2-т “Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “толилуулга” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 98,282.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 23,678.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 74,604.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа зөрчлөөс 98,282.7 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 46,702.0 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Кассын тайланд тусгаагүй, анхан шатны баримтгүй 20,330.0 мянган төгрөгийн ажил, гүйлгээг зардлаар бүртгэж тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “*үнэн зөв байх*”, 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.6-д “*Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна*”, 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “*тохиолдсон байх*”, “*толилуулга*” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтгүйгээр зарцуулсан 20,330.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Ажлаас халагдсан ажилчдад цалингийн урьдчилгаанд 3,348.5 мянган төгрөгийг олгоод, буцаан төлүүлээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “*үнэн зөв байх*”, Хөдөлмөрийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1.3-т “*ажилтны ур чадварын түвшин, гүйцэтгэл, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулсан байх*” гэж заасантай, санхүүгийн тайлагналын “*үнэн зөв байх*”, “*нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалингийн урьдчилгаа 3,348.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

1.Тайлант онд төсвийн хөрөнгөөр 74,604.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авахдаа худалдан авах ажиллагаанд мөрдөх босго үнийг баримталж ажиллаагүй, шууд худалдан авах зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 10.12-д "Энэ хуулийн 10.2, 34.1-д заасан төсөвт өртгийн дээд хязгаарыг Засгийн газар тогтооно", 34 дүгээр зүйлийн 34.1-т "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно" гэж заасантай тус тус нийцээгүй, Санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй зөрчлийг зогсоож , давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

## 5.3 Зөвлөмж

1.Санхүүгийн программд нягтлан бодох бүртгэлийг зөрүүтэй хөтөлж санхүүгийн тайланг экселээр гаргаж ирүүлсэн. Тухайн тайланд нийгмийн даатгалын сангаас санжүүжсэн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийг үндсэн үйл ажиллагааны орлогоор тайлагнаж, үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогыг бүртгээгүй алдааг нягтлан бодогч залруулаагүй болно.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", санхүүгийн тайлагналын "тохиолдсон байх", "толилуулга" гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: НББОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх зөвлөмж өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**  
**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Худалдан авсан хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгээгүй	1	2,969.9	1	2,969.9			1	2,969.9				
Үндсэн үйл ажиллагааны орлогыг дансны ангилал зөрүүлэн тайлагнасан.	1	2,743,711.7			1	2,743,711.7	1	2,743,711.7				
Цалин хөлстэй холбоотой өр төлбөрийг дутуу бүртгэсэн.	1	171,632.0			1	171,632.0	1	171,632.0				
Ажилчдаас илүү тооцон суутгасан НДШ-ийг өглөгөөр бүртгээгүй.	1	346.3	1	346.3			1	346.3				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>2,918,659.9</b>	<b>2</b>	<b>3,316.2</b>	<b>2</b>	<b>2,915,343.7</b>	<b>4</b>	<b>2,918,659.9</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/ мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Кассын тайланд тусгаагүй, анхан шатны баримтгүй ажил, гүйлгээг зардалд тусгасан.	1	20,330.0	1	20,330.0								
Худалдан авах ажиллагаанд мөрдөх босго үнийг баримталж ажиллаагүй шууд худалдан авалт хийсэн.	1	74,604.2			1	74,604.2						

Цалин хөлсийг илүү тооцон олгосон	1	3,348.5	1	3,348.5								
Санхүүгийн программд нягтлан бодох бүртгэлийг зөрүүтэй хөтөлж санхүүгийн тайланг экселээр гаргаж ирүүлсэн. Тухайн тайланд нийгмийн даатгалын сангаас олгосон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийг үндсэн үйл ажиллагааны орлогоор тайлагнаж, үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлогыг бүртгээгүй алдааг нягтлан бодогч залруулаагүй болно.	1	199,890.7					1	199,890.7				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>298,173.4</b>	<b>2</b>	<b>23,678.5</b>	<b>1</b>	<b>74,604.2</b>	<b>1</b>	<b>199,890.7</b>			<b>0</b>	<b>0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/ мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой</b>								
Тайлант онд холбогдох хууль тогтоомжийн дагуу цахим худалдан авалт хийгээгүй.	1	52,941.3					1	52,941.3
Цалингийн зардпаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 4 гүйлгээг хугацаа хоцроон байршуулсан байна.	1	20,000.0					1	20,000.0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>72,941.3</b>	<b>-</b>	<b>-</b>			<b>2</b>	<b>72,941.3</b>



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 410/А0271307

Улаанбаатар хот

НТАГ-2025/063/НА-СТА-ОНӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 74,604,218.00 (далан дөрвөн сая зургаан зуун дөрвөн мянга хоёр зуун арван найм) төгрөгийн бараа, материал худалдан авах үйл ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолтой тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол;" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авах үйл ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулаагүй зөрчлийг зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дарга Э.Болор-Эрдэнэ, нягтлан бодогч Б.Үүрцайх нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨНІ:

АУДИТОР

Л.ОДОНТУЯА

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОТГОНБАЯР



1. Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1465040759



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 03 дугаар сарын 14

№ 113/1027/2025

Улаанбаатар хот

1002-0225/003/НА-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд ажлаас халагдсан ажилчдад цалингийн урьдчилгаанд 3,348,470.00 (гурван сая гурван зуун дөчин найман мянган дөрвөн зуун далан) төгрөгийг олгож, буцаан төлүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон;" заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1.Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй 3,348,470.00 (гурван сая гурван зуун дөчин найман мянган дөрвөн зуун далан) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дарга Э.Болор-Эрдэнэ, нягтлан бодогч Б.Үрцайх нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН1:

АУДИТОР

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

ХЯНАСАН:



Л.ОДОНТУЯА

Д.ОТГОНБАЯР

<sup>1</sup>Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1402050150



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 03 дугаар сарын 14

№ 112/А0231309

Улаанбаатар хот

НТАГ-2025/063/НА-СТА-ОНӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд кассын тайланд тусгаагүй, анхан шатны баримтгүй 20,330,000.00 (хорин сая гурван зуун гучин мянган) төгрөгийн ажил, гүйлгээг зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаадагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн," заалтад заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1.Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ нотлох баримтгүйгээр зарцуулсан 20,330,000.00 (хорин сая гурван зуун гучин мянган) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын Төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 дугаар дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дарга Э.Болор-Эрдэнэ, нягтлан бодогч Б.Үүрцайх нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН1:

АУДИТОР

ХЯНАСАН:  
САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН  
ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР

Л.ОДОНТУЯА

Д.ОТГОНБЯЯР



<sup>1</sup> Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

1435050148